

1. TRIDUMKEY CLIENT ПРОГРАМ СУУЛГАЖ, АЖЛУУЛАХ

1.1 TRIDUMKEY CLIENT ПРОГРАМ

Хэрвээ та компьютертээ **client программ** суулгаагүй бол дараах холбоосоор орж суулгана уу.

Windows 10 ,11 үйлдлийн системтэй бол :

<https://downloads.tridumkey.mn/client/TridumKeyClientSetup.exe>

Windows 7,8 үйлдлийн системтэй бол:


<https://downloads.tridumkey.mn/client/TridumKeyClientSetup271.exe>

Програм суулгах **гарын авлагыг** дараах линкээс харна уу.

https://tridumkey.mn/wp-content/uploads/2023/10/Windows10_11_installation.pdf

Анхааруулга: Тоон гарын үсгийг ашиглахын USB тулд токен төхөөрөмжийг компьютерийнхээ USB портонд залгаж, TridumKey Client програмыг заавал нээх ёстойг анхаарна уу.

Tridumkey програм ажиллаж байгаа бол дэлгэцний баруун доод буланд байрлах сум дээр дарахад дараах хэлбэрээр харагдах болно .




2. ДАН СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ТООН ГАРЫН ҮСГЭЭРЭЭ ХЭРХЭН НЭВТРЭХ ВЭ?

E-Mongolia.mn , E-business.mn , egazar.gov.mn , gaali.mn , ISF.mn зэрэг сайтуудруу USB токентой тоон гарын үсгээр нэвтрэх зааварчилгаа нь бүгд ижил байх болно.



Алхам **1.**
USB Токен төхөөрөмжийг компьютерт залгана.



Алхам **2.**
Та Google Chrome интернэт хөтөч дээр өөрийн ашиглах гэж буй вэб хуудсанд хандаж **НЭВТРЭХ** товч дарна уу.
/ Жишээ болгон E-business.mn /

УНДЭСНИЙ ТАНИЛТ
НЭВТРЭЛТИЙН СИСТЕМ

МУ-ын иргэн

Нэг удаагийн код Банкны эрх **Тоон гарын үсэг**

☐ Клауд тоон гарын үсэг (G-Sign)
☒ **Тоон гарын үсэг (клиент програм татах)**

Регистрийн дугаар Иргэний бүртгэлийн дугаар

Р Д Регистрийн дугаар

Тоон гарын үсэг зурах

QR код уншуулах
 Та ДАН гар утасны аппликейшн дээр байрлах QR уншигчийг ашиглан хялбар, аюулгүй нэвтрээрэй.

Алхам 3.

ДАН танилт нэвтрэлтийн систем -рүү шилжих болно.

Зурагт улаанаар тодруулсан Тоон гарын үсэг гэсэн 2 сонголтыг хийнэ үү

УНДЭСНИЙ ТАНИЛТ
НЭВТРЭЛТИЙН СИСТЕМ

МУ-ын иргэн

Нэг удаагийн код Банкны эрх **Тоон гарын үсэг**

☐ Клауд тоон гарын үсэг (G-Sign)
☒ **Тоон гарын үсэг (клиент програм татах)**

Регистрийн дугаар Иргэний бүртгэлийн дугаар

Р Д Регистрийн дугаар

Тоон гарын үсэг зурах

QR код уншуулах
 Та ДАН гар утасны аппликейшн дээр байрлах QR уншигчийг ашиглан хялбар, аюулгүй нэвтрээрэй.

Алхам 4.

Шараар дугуйлсан талбарт Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигчийн **хувь хүний** регистрийн дугаарын 2 үсгийг сонгон, тоонуудыг бичиж **“Тоон гарын үсэг зурах”** товч дээр дараарай.

Алхам 5.

1.Тоон гарын үсэг эзэмшигчийн нэрийг идэвхигүй байвал дарж идэвхижүүлэх

2.USB токены пин кодыг оруулах /пин код нь 8 оронтой тоо байдаг/

3.Сонгох товч дээр дарснаар үргэлжлэх болно.


Хэрвээ дээрх пин код оруулах **TRIDUMKEY** програмын цонх гарч ирэхгүй байвал Google chrome хөтөч ашиглаж байгаа үгүйг мөн **TRIDUMKEY** программаа ажлуулсан эсэхээ шалгаж үзнэ үү . Тусламж зөвлөгөө авах бол манай лавлах 7012-0722 дугаарт ажлын өдрүүдэд 9-18 цагийн хооронд холбогдох боломжтой.

Алхам 6.

Пин кодыг амжилттай оруулсан бол энэхүү зөвшөөрөх цонх гарч ирнэ .

1."Байгууллага" сонголт дээр дарж хуулийн этгээдийн нэрийг сонгоно. Та аль хуулийн этгээдийн гэрчилгээг сонгож пин код хийсэн тухайн байгууллагын мэдээллийг харуулах болно.

2. Хуулийн этгээдийн нэрийг идэвхижүүлсэн бол улаанаар дугуйлсан "Зөвшөөрөх" товч дээр дараарай.



sso.e-business.mn

Таны дараах мэдээллийг авах хүсэлттэй байна.

Иргэн Байгууллага

Иргэний үнэмлэхний мэдээлэл дамжуулах сервис
Гадаад иргэний мэдээлэл

Та өөрийн мэдээллийг өгөхийг зөвшөөрч байна уу?

Татгалзах Зөвшөөрөх

Та хэрвээ байгууллагын “Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан” биш бол “Иргэн” сонголтыг хийж зөвшөөрөх товчийг дарснаар тухайн системрүү нэвтрэх боломжтой. Газрын цахим систем egazar.gov.mn , E-business.mn зэрэг зарим системд зөвхөн “Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан” бүх үйлчилгээг авах, нэвтрэх тохиргоотой байдаг.